



## НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ЧУУЛГЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Г Улаанбаатар чуулгын албан хаагчийн Г  
ёс зүйн дүрэм батлах, ёс зүйн хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 228 дугаар Захирамжийн нэгдүгээр хавсралтын 2.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус чуулгын албан хаагчид нь өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, ёс зүйн хэм хэмжээг тогтоох зорилго бүхий ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэн ажиллах ёс зүйн хороог
  - Хүний нөөцийн менежер /Б.Гансүх/
  - Нягтлан бодогч /С.Эрдэнэцэцэг/
  - Туслах найруулагч /П.Урнаа/ нарын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
3. Албан хаагчдад ёс зүйн дүрмийг танилцуулах, баримталж ажиллах талаар мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер /Б.Гансүх/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Р.МӨНХСАЙХАН